

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Төслийн нэр: “Дархан-Уул аймгийн Дархан сумын хүн амын өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн нийлүүлэх” аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах Дугаар ДУАХХААГ/202001

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 6.1, 6.3, 6.5 дугаар заалтууд, Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолуудыг үндэслэн эрх бүхий аж ахуй нэгжийг сонгох шалгаруулалтад оролцохыг урьж байна. Үүнд:

Байршил: Дархан-Уул аймаг

Үндсэн чиглэл: Дархан-Уул аймгийн хэмжээнд 2021 оны өвөл, хаврын улиралд иргэд, хэрэглэгчдийн махны хэрэгцээнд зориулан нөөцийн мах бэлтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах

Нэг. Сонгон шалгаруулалтад оролцохоор сонирхож буй хуулийн этгээд нь бүрдүүлсэн материалаа авчирч өгөхдөө бүртгэлийн хураамж 10,000.0 /арван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн сан банк 100190051433 тоот дансанд тушаана. Үүнийг үндэслэн сонгон шалгаруулалтын баримтыг бүртгэн хүлээн авна.

Хоёр. Оролцогч нь саналаа зааврын дагуу битүүмжилсэн байдлаар эх хувь болон хуулбар 1 хувийг бэлтгэн 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 18.00 цагаас өмнө аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын байрны №16 тоот өрөөнд ирүүлнэ.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛИЙГ

Хаяг: Монгол улс, Дархан-уул аймаг, Дархан сум, 8-р баг, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, 2-р давхар №16 тоот өрөө

Утас: 70375138, 99394132, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Г.Тунгалаг

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Т.ГАНБОЛД

БАТЛАВ:

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
/Нөөцийн мах бэлтгэж, нөөцлөх/

№	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Зориулалт	Дархан-Уул аймгийн хүн амын 2021 оны өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны хангамжийг тогтвортжуулах ажлын хүрээнд махны нөөц бурдүүлэх
2	Бэлтгэн нийлүүлэх махны хэмжээ	100 тонн-с багагүй байна
3	Малын мах ангилсан махны шаардлага	Үйлдвэрийн аргаар төхөөрсөн, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан мал, махыг бэлтгэсэн байх ба махны нийт жингийн 30 хувиас багагүй үхэр, 5 хувиас илүүгүй ямаа, үлдэх хэсгийг хонинь махаар бурдүүлнэ.
4	Үйлдвэрийн байр, цех, тасаг	Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн байранд үйл ажиллагаа явуулдаг байх. Ангилан савлах цех, өрөөтэй байх.
5	Стандарт, аюулгүй ажиллагаа	Бэлтгэсэн мах нь MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байх. Үйлдвэрлэлийн зохицой дадал эсвэл НАССР буюу аюулын дүн шинжилгээ ба эзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо стандартыг нэвтрүүлсэн байх.
6	Хадгалалт	Стандартын шаардлага хангасан агуулахтай байх ба хөлдөөх камер, хөргөлтийн төхөөрөмж, жин, хэмжих хэрэгслийн тоноглолтой байх. Махыг малын төрөл тус бүрээр хураана. MNS 5364:2011 Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага хангасан байх.
7	Сав баглаа боодол	Эрүүл ахуйн шаардлага хангасан шошго, ууттай байх. Махыг жижиглэн, хөрөөдөж, яс, махны зохицой харьцааг баримтлан 2-3 кг-ын хэмжээгээр савлана. Махыг хэсэглэн ангилах, савлах ажиллагаанд “MNS 5023:2001. Мах, махан бүтээгдэхүүн, эрүүл ахуйн үндсэн шаардлага”, “MNS CAC RCP 58:2013 Махны эрүүл ахуйн дадлын дүрэм”, хаяг шошгын MNS 6648:2016 стандартын шаардлага хангасан байх
8	Тээвэрлэлт	Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх /хөргөлтийн автомашинтай байх/ MNS 5343:2011. Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлагыг хангасан байх
9	Ажиллах хүчин	Хуулийн этгээдийн технологийн дамжлага дээр ажиллах ажилчид 50-аас доошгүй хувь нь тухай компанийн үндсэн ажилчин байх.
10	Тусгай зөвшөөрөл	Дотооддоо махны чиглэлээр үйл ажиллагаа явуулах А-1 тусгай зөвшөөрөлтэй байх
11	Чанар, аюулгүй байдал	Мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон гарал үүслийг тогтоосон холбогдох баримтыг хавсаргах -Мэргэжлийн хяналтын газрын холбогдох дүгнэлт, шинжилгээний бичиг -Мал эмнэлгийн газрын гарал үүслийн бичиг -Стандарт хэмжилзүйн хэлтсийн холбогдох гэрчилгээ

12	Өр төлбөргүй байх	Банк болон татвар, нийгмийн даатгалын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх
13	Лавлагaa	<ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээ, - Шүүх, - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт
14	Байгууллагын танилцуулга	Ажиллах хүчиний мэдээлэл, тоног төхөөрөмж, машин техник, лабораторийн талаар танилцуулга.
15	Санхүүгийн тайлан, чадварын талаарх мэдээлэл	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан - Ореспецгч аж ахуйн нэгж нь 30 сая төгрөгийн түргэн хөрвэх хөрөнгө, ул хөдлөх хөрөнгө, үйлдвэрийн тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгийн жагсаалт, банкин дахь дансны хуулга 

Хянасан: аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга

П.Батсүх

Боловсруулсан: ХОХБТХ-ийн мэргэжилтэн

У.Дэлгэрмаа

